



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ДАШЗЭГВИЙН
АМАРБАЯСГАЛАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ухнаагийн ОТГОНБАЯР

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-05, Факс: 32-70-16
E-mail: otgonbayar@parliament.mn
http://www.parliament.mn

2025. 07. 09 № уиХ-03/8749
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүд бид санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



У.ОТГОНБАЯР
Ж.АЛДАРЖАВХЛАН
А.АРИУНЗАЯА
Э.БОЛОРМАА
Б.ЖАРГАЛАН
Ч.ЛОДОЙСАМБУУ
Б.НАЙДАЛАА
М.НАРАНТУЯА-НАРА
Н.НОМТОЙБАЯР
Х.ТЭМҮҮЖИН



УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.БААСАНДОРЖ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ухнаагийн ОТГОНБАЯР

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-05, Факс: 32-70-16
E-mail: otgonbayar@parliament.mn
http://www.parliament.mn

2025.07.09 № 212-03/8688
танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүд бид санаачлан боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, товч болон дэлгэрэнгүй танилцуулга, холбогдох тайланг хавсаргав.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

У.ОТГОНБАЯР

Ж.АЛДАРЖАВХЛАН

А.АРИУНЗАЯА

Э.БОЛОРМАА

Б.ЖАРГАЛАН

Ч.ЛОДОЙСАМБУУ

Б.НАЙДАЛАА

М.НАРАНТУЯА-НАРА

Н.НОМТОЙБАЯР

Х.ТЭМҮҮЖИН



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
У.ОТГОНБАЯР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.07.09 № ХЖ/1953

танай _____-ны № _____-т

**Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай**

Таны санаачлан боловсруулсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хавсралт ² хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 8 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“12.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаярын санаачлан боловсруулсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаярын санаачлан боловсруулсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1.Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ.” гэж, Жаран нэгдүгээр зүйлийн 2-т “Засаг дарга тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлын шийдвэрт хориг тавих эрхтэй” гэж, мөн зүйлийн 3-т “тавьсан хоригийг нь Хурал өөрийн төлөөлөгчдийн олонхийн саналаар няцаасан нөхцөлд Засаг дарга уул шийдвэрийг биелүүлэх боломжгүй гэж үзвэл огцрох хүсэлтээ зохих Хурал, Ерөнхий сайд буюу харьяалах дээд шатны Засаг даргад гаргаж болно” гэж тус тус заасан.

Түүнчлэн, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлд иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн шатны Засаг даргыг томилуулахаар нэр дэвшүүлэх, үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах, тайланг хэлэлцэж, үнэлэлт, дүгнэлт өгөх, тухайн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийн талаарх тайланг хэлэлцэж, ажилд нь үнэлэлт, дүгнэлт өгөх, хуульд заасан үндэслэлээр огцруулах талаар дээд шатны Засаг дарга, эсхүл Ерөнхий сайдад санал тавих бүрэн эрхийг, 39 дүгээр зүйлийн 39.1.7-д “иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан Засаг даргад асуулт, асуулга тавих эрх, үүргийг тус тус хэрэгжүүлэхээр хуульчилсан болно.

Гэтэл хууль санаачлагчаас ирүүлсэн хуулийн төсөлд “аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн тавин хувь нь төрийн захиргааны албан хаагч байж болно” гэж тусгасан нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэх, нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулан хэрэгжүүлэх зарчмыг алдагдуулж, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломж, нөхцөлийг хязгаарлах эрсдэл үүсгэж байна.

Мөн төрийн захиргааны албан хаагч гүйцэтгэх болон төлөөлөх үүргийг давхар гүйцэтгэх нь иргэдийн төлөөллийг хэрэгжүүлэх зарчим, бодит байдал

иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тухайн шатны Засаг даргын үйл ажиллагаанд тавих хяналтыг сулруулахаар байна;

2.Хуулийн төсөл нь Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т “улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх зарчим баримтална” гэж, 37 дугаар зүйлийн 37.1.5-д “төрийн албан хаагч нь хэрэв улс төрийн намын гишүүн бол намын гишүүнээс түдгэлзэж, тухайн төрийн албан тушаалд томилогдсон өдрөөс хойш долоо хоногийн дотор байгууллагын захиргаа болон харьяалах намдаа бичгээр албан ёсоор мэдэгдэх” гэж, 49 дүгээр зүйлийн 49.3-т “улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөний аливаа үйл ажиллагаанд дайчлах, чиг үүрэгт нь үл хамаарах ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно” гэж, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4-т “нэр дэвшигч нь төрийн жинхэнэ албан хаагчийн ажил, албан тушаал эрхэлж байгаа бол ээлжит сонгуулийн тухайд сонгуулийн жилийн 08 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө, ээлжит бус, нөхөн, дахин сонгуулийн тухайд энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө эрхэлсэн ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байна” гэж тус тус заасантай зөрчилдөж байна.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР